



## МОНГОЛ БАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2008 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

### Зөвлөмж батлах тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1-ийн 2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зөвлөмж"-ийг хавсралтаар баталсугай.
2. Зөвлөмжийг 2008 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах стратегийг энэхүү зөвлөмжийн 3.1, Стратегийн талаар дотоод дүрэм, журмыг энэхүү зөвлөмжийн 3.2, "Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 3.6-д заасан шаардлагад тус тус нийцүүлэн баталж, 2008 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор Монголбанкинд ирүүлэхийг банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү зөвлөмжийн 3.3.-т заасан шаардлагад нийцсэн мэдээллийн системийг бүрдүүлэх, 3.4.-т заасны дагуу мөнгөн хөрөнгийн цэвэр урсгалыг хэмжих, хянах системийг боловсруулах, 3.7.-д заасан шаардлагад нийцсэн дотоод хяналтын системийг бүрдүүлэх ажлыг гүйцэтгэж, биелэлтийг 2008 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор Монголбанкны Хяналт шалгалтын газарт тайлагнахыг банкны Гүйцэтгэх захирлуудад үүрэг болгосугай.
5. Энэхүү зөвлөмжийн талаар 2008 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор банкуудад сургалт зохион байгуулахыг Хяналт шалгалтын газар /Ж.Ганбаатар/, Банкны сургалтын төв /Б.Лхагвасүрэн/-д даалгасугай.
6. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Ж.Ганбаатар/-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

А.БАТСҮХ

## **ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛИЙГ УДИРДАХ ЗӨВЛӨМЖ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Төв банк /Монгол банк/-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу банкны салбарын тогтвортой байдлыг хангах, Банкны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-д заасны дагуу Монголбанкнаас тогтоосон журмын дагуу арилжааны банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах, хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх заалтыг биелүүлэхэд энэ зөвлөмжийн зорилго оршино.

### **ХОЁР. НЭР ТОМЬЁО**

Энэ зөвлөмжид хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 2.1. “*Хөрвөх чадварын эрсдэл*” (төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл) гэж банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ алдагдаагүй боловч харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох, эсвэл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гаргах нөхцөл байдал үүсэхийг,
- 2.2. “*Актив, пассивын төлөгдөх хугацаа*” гэж актив, пассивын хүлээгдэж буй мөнгөн урсгалыг хугацаагаар ангилсныг,
- 2.3. “*Нөхцөл байдал*” гэж актив, пассивын төлөгдөх хугацаа болон холбогдох мөнгөн урсгалын талаарх таамаглалуудыг,
- 2.4. “*Онцгой нөхцөл байдал*” гэж банк, харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй бодит аюул тулгарсныг,
- 2.5. “*Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*” гэж онцгой нөхцөл байдалд санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэхэд чиглэсэн, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан баримт бичгийг тус тус ойлгоно.

### **ГУРАВ. ЧАНАРЫН ШААРДЛАГА**

- 3.1. Банк өөрийн санхүүгийн чадавхийг хамгаалах, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд давж гарах зорилгыг тусгасан хөрвөх чадварын удирдлагын талаар баримтлах стратегитай байна. Энэхүү стратегид дараахь бодлого, зарчмыг тусгана. Үүнд:
  - 3.1.1. Чанарын болон тоон зорилтуудыг агуулсан хөрвөх чадварын талаар баримтлах бодлого,
  - 3.1.2. Өнгөрсөн цаг хугацааны тоон мэдээлэл болон ирээдүйд үүсч болзошгүй нөхцөл байдлын талаарх төсөөлөлд үндэслэсэн хөрвөх чадварын эрсдэлийн загварыг боловсруулах зарчим,

- 3.1.3. Актив, пассивын бүтэц, үйл ажиллагааны хязгаарлалт, активын хөрвөх чадвар зэргийг тусгасан хөрвөх чадварын эрсдэлийг бууруулан зохистой түвшинд барих зарчим,
  - 3.1.4. Төрөл бүрийн санхүүгийн хэрэгслийг хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагад ашиглах зарчим<sup>1</sup>,
  - 3.1.5. Гадаад валютын хувьд хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зарчим,
  - 3.1.6. Санхүүгийн эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах, тархаан байршуулах зарчим,
  - 3.1.7. Хөрвөх чадварын богино болон урт хугацааны хүндрэлийг шийдэх зарчим,
  - 3.1.8. “Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулах, шинэчлэх зарчим.
- 3.2. Хөрвөх чадварын удирдлагын талаар баримтлах стратегийн талаарх банкны дотоод дүрэм, журамд дараахь асуудлыг тусгана. Үүнд:
- 3.2.1. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэх боломжтой, холбогдох ажилтнуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгсөн үр ашигтай, зохистой удирдлагын системийг бүрдүүлэх,
  - 3.2.2. Хөрвөх чадварын удирдлагыг хариуцсан нэгж нь бусад нэгжтэй хэрхэн хамтран ажиллах, мэдээлэл солилцох,
  - 3.2.3. Хөрвөх чадварын эрсдэлийг валют тус бүрээр болон нийт валютаар хэмжих, хянах аргачлал,
  - 3.2.4. Хөрвөх чадварын удирдлагад ашиглагдах тоон үзүүлэлтүүд, тэдгээрийн хязгаарлалт, хяналт тавих аргачлал,
  - 3.2.5. Тогтоосон хязгаарыг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ,
  - 3.2.6. Тогтоосон хязгаараас гадуур үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл өгөхөд баримтлах шат дараалал,
  - 3.2.7. Хөрвөх чадварын эрсдэлийг хэмжихэд ашиглах арга хэлбэр, нөхцөл байдлыг боловсруулах аргачлал болон тухайн нөхцөл байдалд ашигласан таамаглал, параметруудыг шалгаж, баталгаажуулахад тавигдах шаардлага,
  - 3.2.8. Банкны удирдлага, хөрвөх чадварын удирдлагын асуудал хариуцсан ажилтан болон бусад холбогдох ажилтнуудыг тогтмол мэдээллээр хангах үйл ажиллагаа,

---

<sup>1</sup> Санхүүгийн хэрэгсэл тус бүрийн хэмжээ, хязгаар болон тэдгээрийн мөнгөн урсгалын тооцоо

- 3.2.9. Олон нийтэд тогтмол хүргэх хөрвөх чадварын мэдээллийн жагсаалт,
  - 3.2.10. Хөрвөх чадварын удирдлагын системийн зөв, найдвартай ажиллагааг хянах аргачлал.
- 3.3. Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зорилгоор банк хөрвөх чадварын түвшинг найдвартай хэмжих, хянах, удирдах, тайлагнах зорилго бүхий мэдээллийг банкны удирдлага болон холбогдох ажилтнуудад шуурхай гаргаж өгөх мэдээллийн системийг бүрдүүлнэ. Энэхүү мэдээллийн систем нь дараахь үйлдлийг гүйцэтгэх боломжтой байна. Үүнд:
- 3.3.1. Сонгосон хугацаанд хөрвөх чадварыг өдөр бүр тооцох,
  - 3.3.2. Хөрвөх чадварыг томоохон дүнтэй валютуудаар болон нийтэд нь тооцох,
  - 3.3.3. Энэ зөвлөмжийн 3.2.7-д заасан шаардлагын дагуу боловсруулсан нөхцөл байдлыг шалгах, баталгаажуулах,
  - 3.3.4. Хөрвөх чадварын үзүүлэлтүүдийг тогтоосон хязгаартай харьцуулах,
  - 3.3.5. Банкны хөрвөх чадварын хандлагыг үнэлэх.
- 3.4. Банк дараахь шаардлагыг хангасан, мөнгөн хөрөнгийн цэвэр урсгалыг хэмжих, хянах системийг бүрдүүлнэ. Үүнд:
- 3.4.1. Хөрвөх чадварын удирдлагад шаардлагатай бүх тоон мэдээллийг цаг хугацаанд нь гаргах,
  - 3.4.2. Тайлан тэнцлийн болон тэнцлийн гадуурх дансдыг хугацаагаар ангилах, эх үүсвэрийн өсөлт, бууралтыг хэмжих, харьцуулах,
  - 3.4.3. Цэвэр мөнгөн урсгалыг нэг өдөр, долоо хоног (ажлын 5 өдөр) болон нэг сар, мөн өөрийн сонгосон бусад хугацааны интервалд өдөр бүр тооцох, хянах,
  - 3.4.4. Тооцсон үзүүлэлтүүдэд үндэслэн хөрвөх чадварын хязгаарлалтыг тогтоох,
  - 3.4.5. Мөнгөн урсгалын томоохон хувийг эзэлдэг валютын хувьд тусад нь хязгаарлалт тогтоох,
  - 3.4.6. Банкинд болон банкны системд тохиолдож болох онцгой нөхцөл байдлуудыг тодорхойлж, эрсдэл үүссэн нөхцөлд шаардагдах хөрвөх чадварын хэрэгцээг тооцоолох.
- 3.5. Эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах, төвлөрлийг бууруулах зорилгоор хөрвөх чадварт нөлөөлөхүйц томоохон харилцагчидтай тогтмол харилцаатай байж, тухайн эх үүсвэрийн тогтвортой байдлыг хянан, санхүүжилтийн боломжийн талаар хангалттай мэдээлэлтэй байна. Онцгой нөхцөл байдал тулгарсан тохиолдолд активыг зохистой үнээр худалдах боломжоо хянаж байна.

3.6. Банк онцгой нөхцөл байдал үүссэн үед хангалттай хөрвөх чадвартай байх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан “Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-тэй байна.

3.6.1. “Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд дараахь асуудлуудыг тусгана. Үүнд:

- Банкны дотоод шийдвэр гаргалтад шаардлагатай мэдээллийг цаг хугацаанд нь шуурхай дамжуулах,
- Холбогдох ажилтнуудын үүрэг, хариуцлагыг нарийн тодорхойлох,
- Актив, пассивын өөрчлөлтөд нөлөөлөх арга замын талаар,
- Зээлдэгч, харилцагч нар болон олон нийттэй хэрхэн харилцах талаар,
- Тодорхойлсон нөхцөл байдлын дагуу шаардагдаж болзошгүй хөрвөх чадварыг хангах эх үүсвэрүүд, тэдгээрээс орох боломжтой түргэн борлогдох активын хэмжээг тооцох.

3.6.2. Банкны дотоод болон гадаад нөхцөл байдал их хэмжээгээр өөрчлөгдсөн үед “Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г шинэчилнэ.

3.7. Банк нь хөрвөх чадварын удирдлагын системийн бүрэн бүтэн байдлыг хянах дотоод хяналтын системийг бүрдүүлэх ба энэ нь банкны нэгдсэн дотоод хяналтын системийн салшгүй нэг хэсэг байна.

3.7.1. Хөрвөх чадварын дотоод хяналтын систем нь дараахь зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- Хяналтын орчин,
- Хөрвөх чадварын эрсдэлийг таних, үнэлэх үйл явц,
- Бодлого, үйл явц гэх мэт хяналтын үйл ажиллагааг нэвтрүүлэх,
- Мэдээллийн систем,
- Нэвтрүүлсэн бодлого, үйл явцын биелэлтэд тавих байнгын хяналт.

3.7.2. Дотоод аудитын алба нь удирдлагын болон ажилтны түвшинд хөрвөх чадварын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон аргачлал нь дотоод дүрэм, журамд нийцсэн эсэх, хөрвөх чадварын удирдлага үр ашигтай ажиллаж байгаа эсэх зэргийг шалгаж, шалгалтын акт материалдаа тусгана.

3.7.3. Дотоод аудитын шалгалтын явцад хөрвөх чадварын удирдлагад алдаа, дутагдал гарсан нь илэрвэл дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэхийг шалгана:

- Алдаа, дутагдлыг залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх,
- Системийг шуурхай засч, өөрчилсөн эсэх,
- Хөрвөх чадварын удирдлагыг хариуцсан ажилтанд алдаа, дутагдлын талаар мэдэгдсэн эсэх.

#### **ДӨРӨВ. ТООН ШААРДЛАГА**

- 4.1. Банк нь орох, гарах мөнгөн урсгалын тайланг нэг өдөр, долоо хоног (ажлын 5 өдөр) болон нэг сараар тооцно. Энэхүү тайланг тооцохдоо тэнцлийн болон тэнцлийн гадуурх дансдын мөнгөн урсгалыг харгалзан үзэж, Хавсралт 1-ийн дагуу тооцно (орох гарах мөнгөн урсгалын тайланг тооцох жишээг Хавсралт 2-т үзүүлэв).
- 4.2. Өдөр бүрийн эцэст нэг өдөр, долоо хоног (ажлын 5 өдөр) болон нэг сараар тооцсон орох, гарах мөнгөн урсгалын харьцаа нь 5%-иас багагүй байна.
- 4.3. Холбогдох нэгж нь орох, гарах мөнгөн урсгалын тооцсон харьцааг банкны актив, пассивын удирдлага хариуцсан нэгж болон хөрөнгө зохицуулалт хариуцсан нэгжид өдөр бүр мэдээлж байна.
- 4.4. Банкны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж нь тооцсон орох, гарах мөнгөн урсгалын харьцааг бодит мөнгөн урсгалын харьцаатай харьцуулсан шинжилгээг сар бүр хийх бөгөөд энэхүү шинжилгээний дүнд үндэслэн шаардлагатай тохиолдолд орох, гарах мөнгөн урсгалын харьцааг тооцох аргачлалыг боловсронгуй болгох арга хэмжээ авна (жишээг Хавсралт 3-т үзүүлэв).

#### **ТАВ. БУСАД**

- 5.1. Гадаадын банкны салбар нь дараахь шаардлагыг хангаж байвал энэхүү зөвлөмжийн тоон болон чанарын шаардлага үл хамаарна. Үүнд:
  - 5.1.1. Толгой банкинд хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагатай Монголбанкнаас мэдээлэл солилцох, хамтран ажиллах гэрээ байгуулсан,
  - 5.1.2. Салбарын хөрвөх чадварын удирдлага нь толгой банкны хөрвөх чадварын удирдлагын төвлөрсөн системд бүрэн нэгтгэгдсэн,
  - 5.1.3. Толгой банк нь салбарын хөрвөх чадварыг байнга ханган ажиллах талаар Монголбанкинд бичгээр баталгаа гаргаж өгсөн,
  - 5.1.4. Толгой банкны хөрвөх чадварын удирдлагын системийг ашиглахыг Монголбанкнаас зөвшөөрсөн.

----- ооОоо -----

БАНКНЫ ОРОХ, ГАРАХ МӨНГӨН УРСГАЛЫН ТАЙЛАН

... оны ... сарын ... өдөр

		Нэг өдөр		Долоо хоног		Нэг сар	
		Орох	Гарах	Орох	Гарах	Орох	Гарах
<b>АКТИВЫН УРСГАЛ</b>							
1	Бэлэн мөнгө 1						
2	Монголбанкинд байршуулсан хөрөнгө 2						
3	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө						
4	Төв банкны үнэт цаас						
5	Банк, санхүүгийн байгууллагад олгосон зээл						
6	Бусад зээл						
7	Түрээслүүлсэн хөрөнгө						
8	Бонд болон бусад үнэт цаас						
9	Бусад актив						
<b>ПАССИВЫН УРСГАЛ</b>							
1	Харилцах 3						
2	Хугацаагүй хадгаламж 3						
3	Хугацаатай хадгаламж						
4	Монголбанкинд өгөх өглөг						
5	Бусад банк, санхүүгийн байгууллагад өгөх өглөг						
6	Банкнаас гаргасан өрийн бичиг, үнэт цаас						
7	Бусад пассив						
<b>ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ЗҮЙЛСИЙН УРСГАЛ</b>							
1	Деривативын урсгал						
2	Баталгаа, батлан даалт, standby L/C г м.						
<b>ГАДААД ВАЛЮТЫН НИЙТ НЭЭЛТТЭЙ ПОЗИЦ 4</b>							
<b>ОРОХ, ГАРАХ МӨНГӨН УРСГАЛЫН ЗӨРҮҮ 5</b>							
<b>ОРОХ, ГАРАХ МӨНГӨН УРСГАЛЫН ХАРЬЦАА 6</b>							

- Тайлбар: 1 - Тухайн өдрийн эцсийн бэлэн мөнгөний дүнг "Орох" гэсэн нүдэнд бөглөнө  
 2 - "Заавал байлгах нөөц"-ийн шаардлагад хамаарах дүнг хасч тооцно  
 3 - Харилцах болон хугацаагүй хадгаламжийн мөнгөн урсгалыг өнгөрсөн цаг хугацааны тоон мэдээлэл болон ирээдүйд үүсч болзошгүй нөхцөл байдлын талаарх төсөөлөл зэргийг үндэслэн тооцно  
 4 - Гадаад валютын нийт нээлттэй позицийн абсолют дүнг "Гарах" гэсэн нүдэнд бөглөнө  
 5 - Нийт орох урсгалаас нийт гарах урсгалыг хасч тооцно  
 6 - Орох, гарах мөнгөн урсгалын зөрүүг нийт гарах урсгалын дүнд харьцуулан тооцно

## ОРОХ, ГАРАХ МӨНГӨН УРСГАЛЫН

### ТАЙЛАНГ ТООЦОХ ЖИШЭЭ

Энэ хавсралтад Хавсралт 1-ийн дагуу орох, гарах мөнгөн урсгалын тайланг нэг өдөр болон долоо хоногоор тооцох жишээг авч үзлээ. А банкны орох, гарах мөнгөн урсгалын тайланг хүснэгтэд үзүүлэв.

1. Тухайн өдрийн эцэст А банкны бэлэн мөнгөний үлдэгдэл 200 төгрөг байсан тул нэг өдөр болон долоо хоногийн бэлэн мөнгөний дүн 200 байна.
2. Монголбанкинд байршуулсан хөрөнгийн дараагийн өдөрт (долоо хоногт) чөлөөтэй авах боломжтой дүнгээс заавал байлгах нөөцийн шаардлагад ногдох дүнг хасч, үлдсэн дүн болох 10 (15)-г “Орох” гэсэн нүдэнд, мөн Монголбанкинд дараагийн өдөр (долоо хоног) нэмж байршуулахаар төлөвлөж буй дүн 20 (25)-г “Гарах” гэсэн нүдэнд бөглөсөн.
3. Дараагийн өдөрт (долоо хоногт) хугацаа нь дуусч төлөгдөх зээлийн дүн 90 (265)-г “Бусад зээл”-ийн “Орох” гэсэн нүдэнд, мөн дараагийн өдөрт (долоо хоногт) нэмж олгохоор төлөвлөж буй зээлийн дүн 70 (250)-г “Гарах” гэсэн нүдэнд бөглөсөн.
4. Дараагийн өдөрт (долоо хоногт) төлөгдөх ёстой хуримтлуулж тооцсон хүүгийн авлагын дүн 10 (36) –г “Бусад актив”-ын “Орох” гэсэн нүдэнд бөглөсөн.
5. Бусад төрлийн активын хувьд дээрх маягаар орох, гарах мөнгөн урсгалын дүнгүүдийг бөглөсөн.
6. Банкны өнгөрсөн үеийн мэдээллээс үзэхэд дараагийн өдөрт (долоо хоногт) гарах магадлалтай харилцахын дүн 30 (70) байгаа бөгөөд банкны томоохон харилцагч татвар төлөх зорилгоор маргааш ихээхэн хэмжээний харилцах татах төлөвтэй байгаа тул үүнээс гарч болзошгүй харилцахын дүн 35-ыг нэмж оруулсан (дараагийн долоо хоног нь маргаашийг багтаах тул долоо хоногийн дүнд мөн нэмж өгсөн).
7. Өнгөрсөн үеийн мэдээллээс үзэхэд дараагийн өдөрт (долоо хоногт) гарах магадлалтай хугацаагүй хадгаламжийн дүн 100 (165) байгаа бөгөөд нэмж орох магадлалтай хугацаагүй хадгаламжийн дүн 70 (155) байна.
8. Маргааш (дараагийн долоо хоногт) хугацаа нь дуусч буй хугацаатай хадгаламжийн дүн 75 (95) байгаа бөгөөд нэмж орох магадлалтай хугацаатай хадгаламжийн дүн 85 (90) байна.
9. Дараагийн өдөрт (долоо хоногт) төлөх ёстой хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийн дүн 5 (23) –г “Бусад пассив”-ын “Гарах” гэсэн нүдэнд бөглөсөн.
10. Бусад төрлийн пассивын хувьд дээрх маягаар орох, гарах мөнгөн урсгалын дүнг бөглөсөн.



11. Дараагийн нэг өдөрт (долоо хоногт) балансын гадуурх зүйлстэй холбоотой орох болон гарахаар хүлээгдэж буй мөнгөн урсгалын дүнг тооцож, холбогдох нүдэнд бөглөсөн.
12. Тухайн өдрийн эцсийн гадаад валютын нийт нээлттэй позицийн дүнг абсолют утгаар авч, нэг өдөр болон долоо хоногийн “Гарах” гэсэн нүдэнд бөглөсөн.
13. Дараагийн нэг өдөрт (долоо хоногт) орох нийт урсгалын дүн 617 (1,166) болон гарах нийт урсгалын дүн 602 (1,065) хоёрын ялгавраар тооцсон орох, гарах мөнгөн урсгалын зөрүү нь 15 (101) байна.
14. Дараагийн нэг өдөрт (долоо хоногт) тооцсон орох, гарах мөнгөн урсгалын зөрүү болох 15 (101)-г гарах нийт урсгалын дүн болох 602 (1065)-д харьцуулж тооцсон орох, гарах мөнгөн урсгалын харьцаа нь 2% (9%) байна.
15. Нэг өдрийн хувьд тооцсон орох, гарах мөнгөн урсгалын харьцаа 2% байгаа нь зөвлөмжийн шаардлага болох 5%-иас доогуур байгаа тул хязгаарлалтыг зөрчсөн, харин долоо хоногийн хувьд тооцсон орох, гарах мөнгөн урсгалын харьцаа 9% байгаа нь хязгаарлалтыг зөрчөөгүй байна. Иймд банк дараагийн өдөрт хөрвөх чадварын шаардлагыг хангах арга хэмжээ авах шаардлагатай байна.

## А БАНКНЫ ОРОХ, ГАРАХ МӨНГӨН УРСГАЛЫН ТАЙЛАН

		Нэг өдөр		Долоо хоног	
		Орох	Гарах	Орох	Гарах
<b>АКТИВЫН УРСГАЛ</b>					
1	Бэлэн мөнгө <sup>1</sup>	200		200	
2	Монголбанкинд байршуулсан хөрөнгө <sup>2</sup>	10	20	15	25
3	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	50	40	70	50
4	Төв банкны үнэт цаас	5		10	
5	Банк, санхүүгийн байгууллагад олгосон зээл	2		4	
6	Бусад зээл	90	70	265	250
7	Түрээслүүлсэн хөрөнгө	2		6	
8	Бонд болон бусад үнэт цаас	3		5	
9	Бусад актив	10		36	
<b>ПАССИВЫН УРСГАЛ</b>					
1	Харилцах <sup>3</sup>	40	65	90	105
2	Хугацаагүй хадгаламж <sup>3</sup>	70	100	155	165
3	Хугацаатай хадгаламж	85	75	90	95
4	Монголбанкинд өгөх өглөг	20	45	50	68
5	Бусад банк, санхүүгийн байгууллагад өгөх өглөг	25	15	24	36
6	Банкнаас гаргасан өрийн бичиг, үнэт цаас		130	140	200
7	Бусад пассив		5		23
<b>БАЛАНСЫН ГАДУУРХ ЗҮЙЛСИЙН УРСГАЛ</b>					
1	Деривативын урсгал	5	4	6	7
2	Баталгаа, батлан даалт, standby L/C г.м.		18		26
<b>ГАДААД ВАЛЮТЫН НИЙТ НЭЭЛТТЭЙ ПОЗИЦ <sup>4</sup></b>			15		15
<b>ОРОХ, ГАРАХ МӨНГӨН УРСГАЛЫН ЗӨРҮҮ <sup>5</sup></b>			15		101
<b>ОРОХ, ГАРАХ МӨНГӨН УРСГАЛЫН ХАРЬЦАА <sup>6</sup></b>			<b>2%</b>		<b>9%</b>

## ОРОХ, ГАРАХ МӨНГӨН УРСГАЛЫН ХАРЬЦААГ БОДИТ МӨНГӨН

### УРСГАЛЫН ХАРЬЦААТАЙ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭНИЙ ЖИШЭЭ

Зөвлөмжийн 4.4.-т заасан орох, гарах мөнгөн урсгалын харьцааг хэр бодитой тооцож буйг шалгах харьцангуй энгийн аргын нэг бол бодит мөнгөн урсгалын харьцаатай харьцуулан F-test-ээр шалгах юм. Дараах жишээнд 5 ажиглалтын хувьд (ердийн үед 30 хоног, нэг улирал г.м. илүү урт хугацааны ажиглалтын хувьд хийх нь тохиромжтой) Microsoft Excel ашиглан F-test-г хэрхэн тооцож болохыг харуулав.

	А	В
1	Тооцсон	Бодит
2	0.81	0.25
3	0.76	0.71
4	0.73	0.63
5	0.46	0.05
6	0.58	0.77
	Томъёо	Тайлбар (Дүн)
	=FTEST(A2:A6,B2:B6)	F-test-н утга (0.163)

F-test-ийн утга 0-ээс 1-ийн хооронд байдаг бөгөөд хоёр үзүүлэлт эрс ялгаатай үед 0, ижил үед 1 байдаг. F-test-ийн тооцсон дүнг банк өөрийн сонгосон итгэлцлийн түвшинд харгалзах F-test-ийн утгатай харьцуулж үзээд орох, гарах мөнгөн урсгалыг тооцох аргачлалаа сайжруулах эсэхийг шийднэ. Энэхүү жишээнд F-test-ийн утга 0.163 гарсан нь харьцангуй бага байгаа тул тооцсон орох, гарах мөнгөн урсгалын харьцаа найдвар муутай байна.

----- ооОоо -----